БАТЛАВ.
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
С.МӨНХЧУЛУУН

ДУНДГОВЬ АЙМГИЙН БҮРДИЙН УЯНГА ХӨДӨЛМӨР ЗУСЛАНГЫН ШИНЭ БАРИЛГА, ТОХИЖИЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2025 оны 04-р сарын 10-ны өдөр Дугаар: 32/2025 Адаацаг сум

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тухай тогтоолын 5 дугаар хавсралт 2.3.5 дэх төсөл арга хэмжээг үндэслэв;
2	Барилга байгууламжийн байршил	Дундговь аймгийн Адаацаг сумын 4-р баг, Сүм;
3	Зориулалт, хүчин чадал	Хүүхдийн зуслангийн барилга, 1 давхар; - Эмнэлэгийн барилга, 42.57 м.кв; - Урлаг заалны барилга, 470 м.кв; - Гал тогооны барилга, 230 м.кв; - Мандал бүлэг, 416 м.кв; - Сансар бүлэг, 416 м.кв; - Дөл бүлэг, 416 м.кв; - Оч бүлэг, 416 м.кв; - Агуулахын барилга, 50 м.кв; - Улаан бүч бүлэг, 200.55 м.кв;
4	Төслийн захиалагч	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар;
5	Зураг төсөв зохиох үе шат, хугацаа	- 1 үе шаттай боловсруулна; - Захиалагч, гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно;
6	Хийгдэх ажлын жагсаалт	<u>Буулгах барилга:</u> - Шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж газрыг тэгшлэхээр төлөвлөх; - Агуулахын барилгыг буулгаж шинээр төлөвлөх; - Улаан бүч бүлгийн барилгыг буулгаж тус газар задгай театр төлөвлөх; <u>Урлаг заал, Хоолны заал, Эмнэлэг, 4 бүлгийн барилга:</u> <u>Гадна засал:</u> - Гадна фасадыг тус газрын уур амьсгалд нийцсэн эдэлгээ даахуйц шийдлийг сонгож ажлын зураг төслийг боловсруулах; - Гадна шат, довжооны хэсгийг буулгаж хальтаргаа үүсгэхгүй гадаргуутай материалаар төлөвлөж норм стандартын дагуу шинээр хийх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орчны стандартыг тусгаж засварлах /гадна налуу зам/; <u>Дээвэр:</u> - Шаардлагатай барилгын дээврийн хуучин төмөр материалыг 100 хувь буулгаж шинээр төлөвлөх /шувуу нуруу/; - Парпет /халхавч хана/ хананд усны хаялага төмөр, дээврийн ус зайлуулах хоолой төлөвлөх;

		<u>Дотор засал:</u> - Тус барилгын бүх өрөө тасалгаа, коридорын шал, хана, таазны заслын ажлыг бүрэн хийхээр тусгах. /хана хэсгийн заслыг галын аюулгүй байдлыг хангасан хавтан байхаар төлөвлөх/; - Коридор, үүдний хэсгийн шалыг буулгаж, шинээр чулуун плита шал төлөвлөх; - Шаардлагатай өрөө тасалгааны шал хэсгийн модыг хэсэгчлэн засварлаж будах; - Өрөө, тасалгааны хаалгыг сайн чанарын модон хаалгаар солих, гадна хаалгыг төмөр хүрээтэй хаалгаар иж бүрэн солих; - Шаардлагатай өрөө тасалгааны цонхнуудыг хэсэгчлэн засварлахаар төлөвлөх; - Дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмжийг бүрэн солихоор зураг төслийг боловсруулах; - Өрөө, тасалгааны агааржуулалтын суваг хоолойг засварлах, - Цахилгааны бүрэн засвар хийх; - Дотор холбоо дохиоллын зураг төслийг БНбД-ийн дагуу төлөвлөх; <u>Гадна тохижилт:</u> - Улаан бүч бүлгийн барилгыг буулгаж тус газар задгай театр төлөвлөх; - 3х3 сагсан бөмбөгийн талбай, хашаа, сандал, гүйлтийн зам төлөвлөх; - Элсний волейболын талбай төлөвлөх; - Тоглоомын аюулгүй байдлын стандартыг мөрдөх; MNS ISO8124-1:2011, MNS ISO8124-2:2011 MNS ISO8124-3:2011, MNS ISO8124-4:2011 - Иж бүрдэл тоглоом /гулсуур, савлуур, босоо гулгах багана/ дүүжин даажин, элсний талбай, турник, бялдаржуулах төхөөрөмж; - Олон улсын шаардлагад нийцсэн дизайн, загвар нь орчны тохижилтод нийцсэн сайн чанарын шар өнгийн лед бүхий нарны эрчим хүчээр хангагдах гэрэл төлөвлөх; - Явган хүний замыг өнгөт хавтангаар төлөвлөх; - Одоо байгаа явган хүний замтай уялдуулан, үргэлжлүүлэн явган зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулж орц гарцыг нэмэгдүүлэх; - “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS6056:2009 стандартын дагуу төлөвлөх; - “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS6056:2009 стандарт, “Тахир дутуу хүнд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД 31-101-04, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлага хангасан зураг төсөл зохиох заавар” БД 31-112-11 норм стандартын шаардлага хангасан замын өргөн орон зайтай байна; - Тухайн орон нутгийн цаг уурын нөхцөлд тохирсон 5-аас дээш насны модны суулгац суулгахаар төлөвлөх;

		- Усалгааны системийг иж бүрэн шийдвэрлэх /захиалагчтай зөвшилцөх/; - Гадна хашааны өнгө үзэмжийг сайжруулан будахаар тусгах; - Архитектур орон зайн төлөвлөлтөд нийцсэн ландшафтын шийдэл бүхий тохижилтын элементүүдийг /сүүдрэвч, сандал, ангилан ялгах хогийн сав/ явган хүний зам төлөвлөх; - Хашааны гадна Монгол уламжлалт аж ахуйн соёлыг дэмжих орчныг бүрдүүлсэн отог төлөвлөх; <u>Ариун цэврийн барилга байгууламж:</u> - Эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөг холбогдох БНбД-ийн дагуу төлөвлөнө. Мөн ариун цэврийн нэг өрөөг хөгжлийн бэрхшээлтэй хүний стандарт норм дүрмийн дагуу төлөвлөх шаардлагатай. - Дотор болон гадна нийтийн угаалтуур төлөвлөх; - Шүршүүрийн өрөө шинээр төлөвлөх /эрэгтэй, эмэгтэй хэсэгтэй/; - Агааржуулалтын системийг норм норматив дагуу төлөвлөх; <u>Инженерийн шугам сүлжээ:</u> - Ариун цэврийн байгууламжийн хүчин чадалд тохирсон цэвэр усны нөөцийн сав төлөвлөх. - Бохир ус хуримтлуулах 4,5 - 5м3 багтаамжтай цооног төлөвлөх; - Бохир усны цооног нь “Нүхэн жорлон угаадасны нүх, Техникийн шаардлага” MNS 5924 : 2015 стандартын шаардлага хангасан байна. - Ариун цэврийн өрөөний дулаалга, өнгөлгөө, доторлогоонд орох материалууд нь галын аюулгүй байдал болон эрүүл ахуйн шаардлага хангасан гарал үүсэл, тохирлын баталгаажуулалтад хамрагдсан гэрчилгээтэй байна. Зураг төслийн байгууллага газар дээр нь үзлэг, хэмжилт хийж бусад шаардлагатай засварын ажлын зураг төсвийг боловсруулах;
7	Зураг төслийн баримт бичгийн бүрдэл	<u>Баримт бичгийн иж бүрдэл:</u> - Эрүүл ахуйн болон галын аюулгүй байдлын дүгнэлт; - Онцгой байдлын газраас галын аюулгүй байдлын дүгнэлт; - Магадлалын ерөнхий дүгнэлт /Хавсралт дүгнэлтийн хамт/ <u>Зураг төслийн иж бүрдэл:</u> - Ажлын зураг, төсөв; - Персиктив зураг; Эх болон хуулбар хувь тус бүр нэг. Ажлын зураг төсвийг CD-ээр 1 хувь өгнө.
8	Зураг төслийн байгууллага	Зураг төсөл боловсруулах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллага байна;
9	Онцгой нөхцөл	Засварын ажлын хүрээнд ашиглагдах хавтан нь галын аюулгүй байдлын шаардлага хангасан байх. Мөн барилгын заслын ажилд хэрэглэгдэх бүх төрлийн материалууд нь чанарын болон эрүүл ахуйн норм, стандартад нийцсэн байна;

10	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД 21-02-02/; - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-01-02/;
11	Эдийн засгийн тооцоо төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;
12	Зөвшилцөх байгууллага	Аймгийн ГХБХБГ, Ерөнхий архитектор, ЗДТГ, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, инженерийн хангамжийн байгууллагууд;

Тайлбар:

- Зураг төслийн байгууллага газар дээр нь үзлэг, хэмжилт хийж засварын ажлын зураг төсвийг боловсруулах шаардлагатай.
- Зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт өөрчлөлт оруулах бол захиалагчтай зөвшилцөж шийдвэрлэх.

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Б.ЛХАГВАБААТАР

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Ж.УЯНГА

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА — Э.ЧАГНААДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Э.ЭНХМЭНД

ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТР, ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — М.ӨЛЗИЙ